

ЁС ЗҮЙН СУДЛАХ ЗҮЙЛ,
ҮҮРЭГ, АЧ ХОЛБОГДОЛ



Үгийн утга

- Ethos – Аристотель

- Moral хэмээх ойлголт нь дараах утгатай. Үүнд:

А. Хүний сайн, муу зан чанар, зөв буруугийн ялгаа, хүний зан байдлын хэм хэмжээ

Б. Сайн үйлийн ерөнхий чиглэл

- Эндээс харахад ёс суртахуун бол хүний зан төлөв, зан чанартай холбоотой ойлголт юм.



**ЁС СУРТАХУУН
ГЭЖ ЮУ ВЭ?**



- Ёс суртахууны үүсэл, мөн чанар.
- Ёс суртахууны бүтэц.
- Ёс суртахууны ухамсар, ёс суртахууны харилцаа, ёс суртахууны практик
- Ёс суртахууны үүрэг



Роберт Вольф:



- “Ёс зүй нь хүмүүс бид өөр бусдад болон өөрөө өөртөө хэрхэн хандаж, биеэ хэрхэн авч явахыг системтэйгээр судлах, мөн түүнчлэн хүмүүсийн ямар хэв маяг эрхэм сайн буюу үлгэр дууриал болох, ямар нь муу муухай буюу шүүмжилж, засаж залруулж байвал зохихыг философиор судалдаг”




Английн философич Ф.Бэкон:



- Ёс зүй нь үнэн зөвийг л илэрхийлдэг. Ёс зүйн судлагдахуун нь хүний хүсэл зориг.
- Аливаа үнэлэмж нь ёс суртахууны сайн, муугаар тодорхойлогдоно.



Сократ



“Амьдралын утга учрыг
мэдэхгүй бол амьд
явах хэрэггүй”

“Аз жаргалыг мэдрэх нь
үнэнийг танин мэдэх
чадвараас бөгөөд оюун
санааны хамгийн чухал
эрхэмлэл”



Ёс суртахууны тогтолцоо

Хэм хэмжээ

Үнэлэмж

Эрхэмлэл

Зарчим



Ёс суртахууны ХЭМ ХЭМЖЭЭ

- Нийтээр хүлээн зөвшөөрсөн, дагаж мөрдөх шаардлагыг ХЭМ ХЭМЖЭЭ ГЭНЭ.
- Хэм хэмжээ нь сэтгэл хөдлөл, зан байдлын тодорхой дүрэм, журам, зөвлөмж юм.
- Хэм хэмжээ нь нийтийн үйл ажиллагаа, харилцааг тэнцвэржүүлэх үүрэгтэй.
- Ёс суртахуунтай, ёс суртахуунгүй эсэхийн хязгаарыг ТОГТООХ НӨХЦӨЛ



Ёс суртахууны хэм
хэмжээ

Ерөнхий

Тусгай (Багшийн,
эмчийн гм)



Ёс суртахууны шаардлага ямар хэлбэрээр илэрдэг вэ?

- Дэмжих
- Зөвшөөрөх
- Хориглох
- Үгүйсгэх
- Сануулах
- Анхааруулах
- Итгэл үзүүлэх



Ёс суртахууны бүтэц

```
graph TD; A[Ёс суртахууны бүтэц] --> B[Ухамсар]; A --> C[Үйлдэл]; A --> D[Харилцаа]; B --> E[Хүмүүсийн харилцаанд нөлөөлдөг танин мэдэхүй, мэдлэг, үзэл санаа]; C --> F[Амьдрал үйл ажиллагаанд мөрддөг ёс горим хэм хэмжээ]; D --> G[Нийгмийн амьдралын суурь];
```

Ухамсар

Хүмүүсийн харилцаанд
нөлөөлдөг танин мэдэхүй,
мэдлэг, үзэл санаа

Үйлдэл

Амьдрал үйл ажиллагаанд
мөрддөг ёс горим хэм
хэмжээ

Харилцаа

Нийгмийн амьдралын
суурь



Ёс суртахууны нийгмийн харилцаанд гүйцэтгэх үүрэг

■ Хэм хэмжээний үүрэг

Ёс суртахууны хэм хэмжээ нь харилцаа, зан авир, биеэ авч явах зохицуулдаг арга хэрэгсэл юм.

/Сонголт/

■ Хүмүүжлийн үүрэг – Хүнийг ёс суртахууны төлөвшлөөр нь тодорхойлдог.



Ёс суртахууны нийгмийн харилцаанд гүйцэтгэх үүрэг

■ Танин мэдэхүйн үүрэг

Ёс суртахууны танин мэдэхүйн төвшин /ердийн болон онолын/

Ёс зүйн мэдлэгтэй болсноор хувийн зан байдал, мэдрэмж, сэтгэлгээг зөв хандлагад чиглүүлэх, ёс суртахууны асуудлыг шийдвэрлэхэд илүү ухамсартай хандах ...ГМ



Ёс суртахууны нийгмийн харилцаанд гүйцэтгэх үүрэг

■ Үнэлэмжийн үүрэг

Өөрийн болон бусдын зан байдалд үнэлгээ өгдөг
утгаараа ёс суртахуун үнэлэмжийн үүрэг гүйцэтгэнэ.

/Юуг шударга гэх вэ? Хайр гэж юу вэ? Юуг хайрлавал
зохилтой вэ? Сайн хүн гэж ямар хүнийг хэлэх вэ? гэх
мэт/



Ёс суртахууны нийгмийн харилцаанд гүйцэтгэх үүрэг

■ Зохицуулах үүрэгтэй

Ёс суртахууны дэмжих болон хориглох шаардлагууд нь хүмүүсийн зан байдлыг зохицуулдаг.



ЁС СУРТАХУУНТАЙ БАЙХ ШАЛТГААН



Ёс суртахууны мөн чанар

- Бидний үйл ажиллагаа ёс суртахууны хэм хэмжээ, зарчимд захирагдах нь зайлшгүй.
- Бидний хүсэл зоригийг хянадаг.



- Ёс суртахуун бол хүн чанарын шалгуур
- Ёс суртахуунтай байх нь харилцааны зөрчлийг багасгаж өгдөг.
- Ёс суртахуун бол хүний мөн чанар



Шалтгаан -1

- Анхны утга нь амьтдын орогнох газар, шувууны үүр, орон сууц
- Орчин үед боловсролтой хүний “орогнох сууц” нь ёс суртахуун



Хүн эзэмшсэн боловсролоороо өөрийн
“сууц”-ыг буй болгон амьдардаг.



Шалтгаан - 2

Ёс суртахууны чадавх

- Нийгэмдээ амьдрахдаа өөрийгөө болон орчноо сайн мэдсэн,
- Бусдын амьдрал, ажилд саад учруулдаггүй
- Амьдрах хүсэл тэмүүлэлтэй,
- Хариуцлагатай байх.

Дүгнэлт: Амьдарч, ажиллаж буй орчиндоо зөв зохицон амар тайван амьдрах чадвар



Шалтгаан - 3

Зорилго


Хэрэгсэл



“Байгаль юуг ч
дэмий
бүтээдэггүй”
Аристотель



Шалтгаан - 4



Хүн амьтан хоёр юугаараа
ялгаатай вэ?

- Хүн бол ер нь нэг төрлийн адгуус.
Ганцхан мораль л түүнийг хүн болгодог”
И.Кант



Дүгнэлт

- Хариуцлагыг бий болгодог. Хариуцлагатай иргэн бол тухайн улс үндэстний үнэт зүйл.
- Амжилтын эх үндэс
- Нэр төртэй сайхан амьдрах нь хувь заяанаас бус ёс суртахуунаас хамаарна.
- Ёс суртахуунтай хүн оюуны эрх чөлөөг мэдэрдэг. /Эрх чөлөө - дур зоргын бус харин бие даасан, бусдаас хараат бус байдал/

